

Говь Алтай аймаг дахь Төрийн аудитын газар



Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН БАЙДАЛ
ҮАГ-НАГ-/2017/01-НА/



ОНХС-гийн эх үүсвэрээс 769.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь
өмнөх онтой харьцуулахад 25 дахин өссөн үзүүлэлттэй, мөн дотоодын хяналт
хангалтгүй байна.

Алтай хот

2017 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

Говь-Алтай аймгийн Аудитын
газрын
III баг

Дарга, Тэргүүлэх аудитор
Х.Түвшинбаяр
Утас: 99489309

Аудитын менежер
Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677

Ахлах аудитор
Д.Цэрэнханд
Утас: 99147999

Шинжээч:
Ц.Сайханжаргал
Утас: 88665099
Шинжээч:
Н.Монголжийбуу
Утас: 9400818

2017 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70483413, 70484055 дугаарын
утас, 70484030 дугаарын
факсаар харилцана уу.

Хаяг:
Говь-Алтай аймаг
Есөнбулаг сум
Баянхайрхан баг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....

НЭГ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗӨВХӨН ОНХНС-ААС ОЛГОХ ЭХ ҮҮСВЭРИЙН ХЭМЖЭЭНД ТӨЛӨВЛӨЖ СУМДЫН САНХҮҮЖИЛТИЙГ БУУРУУЛЖ АЙМГИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ӨСГӨЖ ТОДОТГОСОН БАЙНА.

ХОЁР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН 22 ХУВЬ БУЮУ 769.7 САЯ ТӨГРӨГИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦЭХГҮЙ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН БАЙНА.

ГУРАВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ, ТАЙЛАН МЭДЭЭГ СУМУУД ИРҮҮЛЭЭГҮЙ ТУЛ ХЭЛЭЛЦЭЭГҮЙ БАЙНА.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГ	Засгийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
БИНХ	Багийн Иргэдийн нийтийн хурал
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ОНОХАА-	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг дарга
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
СС	Сангийн сайд
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ОНО	Олон нийтийн оролцоотой
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ТАХ	Төсөл арга хэмжээ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторт УАГ-аас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөө, Говь Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулан дүнг УИХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж хуваарилсан эсэх
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх

Аудитын явцад “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж тайлагнана.

Аудитын хамрах хүрээ

- Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлүүд
- Аймгийн ИТХ-ийн тогтоол
- Сумдын ИТХ-ийн тогтоол
- ИТХ, БИНХ-ийн протоколууд
- Худалдан авах ажиллагаа
- Аймаг, сумын Засаг даргын захирамжууд
- Үнэлгээний хорооны шийдвэрүүд
- Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ
- ИТХ-ийн дэргэдэх хяналтын хорооны хяналт шалгалтын материалууд
- Ажлын санхүүжилтийн хуваарь, ОНХС-гийн дансны хуулга
- Төсөл арга хэмжээг хүлээж авах, ашиглалтанд оруулах акт

- Хөндлөнгийн хяналт шалгалтын материалууд
- Төсөл арга хэмжээний ТЭЗҮ-үүд, зураг төсөв
- ОНХС-гийн хэрэгжилтийн тайлан, мэдээ
- Төсөл арга хэмжээний мэдээлэлийн сан
- Хөрөнгийн бүртгэл, хамгаалалт
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг үзэх
- Бусад

Үндсэн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, зорилго

ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангасны үндсэн дээр иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин бүрдүүлэхэд чиглэгддэг.

Үндсэн мэдээлэл:

2016 оны “Төсвийн тухай” хуульд ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 131.0 тэрбум төгрөгөөр баталсныг Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 09-ны сарын 23-ны өдрийн хуулиар 120.3 тэрбум төгрөг болгон өөрчлөн баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 13 тоот тогтоолоор ОНХС-ийн орлогыг 6,569.7 сая төгрөгөөр төлөвлөж, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс сумдын ОНХС-д 3,941.4 сая төгрөг, аймгийн ОНХС-д 2,627.9 сая төгрөг нийт 6,569.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан байна.

Бодит гүйцэтгэлээр ОНХНС-аас 5,693.6 сая төгрөгийн санхүүжилт олгогдон, сумдын ОНХС-д 3,102.5 сая төгрөг, аймгийн ОНХС-д 2,591.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хуваарилж олгосон байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дэд хөтөлбөр боловсруулан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын нөхцөл байдал, үр дүнд шинжилгээ хийх, шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, анхан баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, бодит байдал дээр оршин байгааг үзэх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудит хийж буй асуудлуудыг нэгтгэж тайланд тусгахдаа дараах арга зүйг ашиглаж баримтжууллаа.

- ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахдаа сум дүүргийн хөгжлийн индексийг үнэн зөв тооцсон эсэхийг үзэх
- БИНХ-ын тэмдэглэл, иргэдийн санал асуулгын хуудсыг хурлын шийдвэртэй тулган баталгаажуулах
- БИНХ-аас гарсан шийдвэрийг тухайн шатны ЗДТГ, сумын ИТХ-ын шийдвэртэй нийцэж байгааг тулган баталгаажуулах
- Тухайн шатны ЗДТГ, ИТХ-ийн шийдвэр нь орон нутгийн хөгжлийн бодлого, ОНХС-ийн журамтай нийцэж байгааг судлах

- Эх үүсвэрийн төлөвлөлтийг батлагдсан төсөл арга хэмжээнд нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг үзэх
- Худалдан авах ажиллагааг холбогдох эрх зүйн акттай нийцэж байгааг үзэх
- ОНХС-ийн дансны хуулгыг ажлын санхүүжилтийн хуваарь, гэрээний дүнтэй тулган баталгаажуулах
- Төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэх гэрээг гэрээний батлагдсан загвартай тулган баталгаажуулах
- Сангийн хөрөнгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалд нийцэж байгааг үзэх
- ТЭЗҮ-ийг ажлын гүйцэтгэлтэй тулган баталгаажуулах
- Төсөл арга хэмжээнд заасан ажлыг бодит байдал дээр хийгдсэн ажилтай харьцуулан судлах, зураг авалт хийх, ажиглалт хийх,
- Хөрөнгө оруулалтын ажлыг ашиглалтанд хүлээн авсан комиссын актыг бодит байдалтай тулган баталгаажуулах
- Гэрээний дагуу хугацаа хоцорсон ажлуудад алданги тооцох
- Байгууллагын дотоод хяналт, төрийн сан болон бусад байгууллагуудын хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг үзэх

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитад дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгоно.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нэгдсэн төсвийн тухай хууль
- 2016 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 30-р тогтоол /ОНХНС болон ОНХС-гаас олгох шилжүүлэг тооцох аргачлал/
- Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол /Босго үнэ батлах тухай/
- Сангийн сайдын 2014 оны 43-р тушаал /Заавар батлах тухай/
- Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаал
- Сангийн сайдын 2012 оны 244-р тушаал /Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам/

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, стандартыг хангуулж, нийцлийн аудитын багийн ахлах аудитор

Д.Цэрэнханд, шинжээч Ц.Сайханжаргал, Н.Монголжийбуу нар нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хөтөлбөр

Аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-аас эхэлж, 04 сарын 28-ны өдөр дуусган тэргүүлэх аудиторoor хянан баталгаажуулан 2017 оны 04 сарын 30-ны өдөр ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын шийдвэр болон хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурьдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр оруулж өглөө.

Аудитын тайланг шалгадагч байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр сурталчилна.

Аудит хийхэд учирсан бэрхшээл:

- ОНХС-гаар хийгдсэн ажлуудын бодит байдалтай танилцахад цаг хугацаа их шаардсан зарим сумдын багуудад хийгдсэн ажлуудыг үзэхэд алслагдмал, цаг агаарын байдал хүнд байсан бөгөөд зарим унаа очихгүй газарт мориор 1 бүтэн өдөр явж ажлуудыг үзсэн.

БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗӨВХӨН ОНХНС-ААС ОЛГОХ ЭХ ҮҮСВЭРИЙН ХЭМЖЭЭНД ТӨЛӨВЛӨЖ СУМДЫН САНХҮҮЖИЛТИЙГ БУУРУУЛЖ АЙМГИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ӨСГӨЖ ТОДОТГОСОН БАЙНА.

1.1 Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсөл боловруулах журмын дагуу төлөвлөөгүй байна.

МУ-ын 2016 оны төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд ОНХНС-аас Говь-Алтай аймгийн орон нутгийн хөгжлийн санд 5,693.7 сая төгрөгийг олгохоор төлөвлөж баталжээ.

***Тайлбар:** ОНХНС-аас аймагт олгох шилжүүлгийг баталсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн эсэхийг аймагт үзэх боломжгүй юм.*

Засгийн газрын 2014 оны 242 дугаар тогтоолоор “Сумын хөгжлийн индекс” тооцох аргачлалыг баталж, 2014 оны 4 дүгээр улиралд багтаан зарлан, цаашид 2 жилд 1 удаа тооцож байхыг даалгасан. Гэтэл Сангийн яамнаас уг индексийг тооцоогүй байгаа нь Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1¹ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй болохыг харуулж байна.

Дээрх индексийг тооцоогүйгээс аймгийн удирдлага Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3.1² заалтыг зөрчсөн байна. Өөрөөр хэлбэл 2013 оны хөгжлийн индексээр тооцож сумдад 3,941.8 сая төгрөгийг олгохоор төлөвлөсөн байна.

Индексээр тооцоход Есөнбулаг суманд 379.9 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хийгдэх ёстой байтал аймгийн ИТХ-аас батлахдаа сумдад олгох шилжүүлгээс хасч, Есөнбулаг сум дээр нэмж тодотгон, 858.3 сая төгрөгөөр баталсан зөрчил илэрлээ.

Аймгийн ИТХ-ийн 2015 оны 12 дугаар сарын 04-ны 03 дугаар тогтоолоор сумдад олгох шилжүүлгийг 3,941.8 сая төгрөгөөр баталсан бол 2016 оны 12 дугаар сарын 05-ны 09 дугаар тогтоолоор 3,463.4 сая төгрөгөөр буюу 478.4 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. /хавсралт №1/

Аймгийн удирдлагууд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтийн дээрх тооцооллыг үл харгалзан бууруулж баталснаас сумдад төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр дутагдах, өртэй гарах, нөгөө талаас төлөвлөгдөөгүй ажлууд хийгдэхэд хүргэсэн байна.

1.2 Аймаг, нийслэл сум дүүргийн ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө орлогын нэр төрлөөр тооцож төлөвлөх тал дээр санаачлагагүй ажиллажээ.

Аймаг нь “2016 оны төсвийн төсөл”-ийг Сангийн яаманд хүргүүлэхдээ ОНХС-ийн эх үүсвэрийн талаар санал тусгаагүй, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр

¹ Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтийг хангуулах

² Орон нутгийн хөгжлийн индексийг үндэслэж тогтооно.

тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 6.1³-д заасан заалтыг биелүүлээгүй байна.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг батлахдаа ОНХНС-аас 2,230.2 сая төгрөгийн санхүүжилт, шилжих үлдэгдлээс 92.6 сая төгрөгийг, хайгуул лицензийн төлбөрийн орлогоос 130.0 сая төгрөгийг нийт 2,452.9 сая төгрөгийг ОНХС-д оруулахаар тооцож баталжээ.

Алтай сумын тухайд хандив тусламж бусад эх үүсвэрээс 21.5 сая төгрөгийг оруулахаар төлөвлөсөн байна. Харин бусад сумдын тухайд санаачилгагүй ажилласан байна. /Хавсралт №2/

Аймгийн 2016 оны төсвийн төсөлд ОНХС-д татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн орлого, үндсэн тэнцлийн ашигийн суурь зарлагатай тэнцэх хэсэг, зарлагын бодит хэмнэлтийн орлогуудыг нэмэгдүүлэхэд санаачлага гаргаагүй байна.

1.3 Аймаг ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр бүрдүүлээгүй байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг 5,693.7 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 5,693.7 сая төгрөг буюу санхүүжилтээ бүрэн авсан байна.

Хайгуул лицензийн төлбөрийн орлогоос 130.0 сая төгрөгийг оруулахаар тооцож төлөвлөсөн бөгөөд хэрэгжээгүй байна.

Бусад орлогоос 4.8 сая төгрөгийг оруулахаар /Алтай сум банз, малын үнэ/ төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 74.3 сая төгрөг орж, 69.5 сая төгрөгөөр орлого давсан мэт харагдаж байгаа боловч, энэ нь аймгийн ОНХС-аас өмнөх онд үйлдвэр байгуулах дэмжлэгэд олгосон зээлийн эргэн төлөлт 25.4 сая төгрөг, Алтай сумын малжуулах төсөл болон банзны үнэ 6.1 сая төгрөг, Жаргалан сумын актын төлбөрийн орлого 0.2 сая төгрөг, Тонхил сумын малжуулах төслийн 7.9 сая төгрөг, Төгрөг сумын өвсний үнэ 2.9 сая төгрөг, Хөхморьт сумын өвсний үнэ 2.6 сая төгрөг, Цээл сумын малжуулах төсөл болон тендерийн баримт бичгийн үнэ 4.0 сая төгрөг, Цогт сумын ОНХО-оос тодотгосон 25.0 сая төгрөг байна.

Мөн Бугат, Дарив сумдын ОНХС-аас сумдын ой болж байгаатай холбоотойгоор бүтээн байгуулалт дэмжлэгт 29.3 сая төгрөгийг зориулалт бусаар олгосон байна.

³ Аймаг, нийслэлийн Засаг дарга ОНХНС болон ОНХС-гаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны ОНХС-гийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө. 6.1.1 ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлэг: 6.1.2 Аймаг, нийслэлийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг: 6.1.3 Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох хөрөнгө: 6.1.4 Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр: 6.1.5 Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод, гадаадын хандив тусламж

Хүснэгт №1: ОНХС-гийн эх үүсвэрийн төлөвлөлт, гүйцэтгэл

	ОНХС-гаас шилжүүлэг	Орон нутгийн орлого			Орлогын дүн
		Ашигт малтмалын орлого	Гадаад дотоод хандив тусламж	Бусад	
Төлөвлөлт	5,693.7	130.0	21.5	4.8	5,849.9
Гүйцэтгэл	5,693.7	0	21.5	74.3	5,760.1
Давсан - /гасарсан + /	0	+130.0	0	-69.5	-89.8

1.4 Аймгийн ОНХС-аас олгосон шилжүүлгийг аймгийн ИТХ батлахдаа хууль, заавар, журмыг зөрчин баталж, санхүүжилтийг илүү дутуу олгосон байна.

Аймгийн 2016 оны төсвийн төсөлд сумдад олгох шилжүүлгийг 3,941.8 сая төгрөгөөр буюу орлогын шилжүүлгийн 60%-ийг олгохоор анх төлөвлөжээ. Сүүлд дахин төлөвлөж 3,463.4 сая төгрөгөөр буюу 5,693.7 сая төгрөгийн 61%-ийг сумдад хуваарилахаар баталжээ. Гэтэл аймгийн ИТХ-аас санхүүжилтийг батлахдаа 54.5%-ийг сумдад, 45.5%-ийг аймгийн ОНХС-д хуваарилсан нь Төсвийн тухай хуулийн 59.2⁴ дахь заалтыг зөрчсөн байна. Өөрөөр хэлбэл аймгийн ОНХС-д орсон нийт орлого 5,693.7 сая төгрөгөөс сумдад 3,102.0 сая төгрөг буюу 54.5%-ийг гүйцэтгэлээр хуваарилжээ. Үүнээс харахад сумдад 4.3%-ийн эх үүсвэрийг дутуу олгосон байна. /хавсралт №3/

Мөн сумдад олгох санхүүжилтийг батлагдсан төсвийн гүйцэтгэлтэй харьцуулж үзвэл сумдад олгох шилжүүлгийг 361.3 сая төгрөгөөр дутуу олгож, аймгийн ОНХС-д илүү олгосон байна. /хавсралт №4/

БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН 22 ХУВЬ БУЮУ 769.7 САЯ ТӨГРӨГИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦЭХГҮЙ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН БАЙНА.

2.1 ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд 2016 онд шинээр хэрэгжүүлэхээр 4,611.5 сая төгрөгийн 345 багц төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймаг, сум дүүргийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан байна. /хавсралт №5/

⁴ Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60%-иас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хувиарлана

2.2 ОНХС-гаас иргэдийн санал аваагүй ТАХ-г шууд баталдаг зөрчил дахин давтан гарсаар байна.

Мөн аймаг, сумдын удирдлага нь ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс авсан саналыг нэгтгэж ИНХ-д хэлэлцүүлэх жагсаалтыг бэлтгэсэн боловч, хуралд оролцсон иргэдийн ирцийг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, нэгдсэн жагсаалтыг төсөл хөтөлбөр тус бүрээр хэлэлцэн батлаагүй, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг ИТХ-аар баталсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4⁵, 60.3.6⁶ дахь заалт, Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.1 в⁷, 12.2.2 а⁸, б⁹, в¹⁰, г¹¹ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Тухайлбал: Аймгийн ЗДТГ-аас 271.1 сая төгрөгийн 2 багц төсөл арга хэмжээ, Хөхморьт сумын ЗДТГ-аас 9.7 сая төгрөгийн 1 ТАХ-г, Есөнбулаг сумын ЗДТГ-аас 8.6 сая төгрөгийн 2 ТАХ-г тус тус иргэдээс санал аваагүй байхад эрэмбэлж ИТХ-д оруулан батлуулсан байна.

Мөн Алтай сумын ИТХ-аас 23.7 сая төгрөгийн 3 ТАХ-г, Баянуул сумын ИТХ-аас 0.75 сая төгрөгийн 1 ТАХ-г, Бигэр сумын ИТХ 33.0 сая төгрөгийн 3 ТАХ-г, Бугат сумын ИТХ-аас 20.0 сая төгрөгийн 1 ТАХ-г, Дарив сумын ИТХ-аас 0.75 сая төгрөгийн 1 ТАХ-г, Жаргалан сумын ИТХ-аас 1.9 сая төгрөгийн 1 ТАХ-г, Төгрөг сумын ИТХ-аас 10.6 сая төгрөгийн 3 ТАХ-г, Халиун сумын ИТХ-аас 9.0 сая төгрөгийн 3 ТАХ-г, Хөхморьт сум 19.0 сая төгрөгийн 2 ТАХ-г, Цогт сумын ИТХ-аас 5.7 сая төгрөгийн 2 ТАХ-г, Цээл сумын ИТХ-аас 76.6 сая төгрөгийн 5 ТАХ-г, Шарга сумын ИТХ-аас 20.0 сая төгрөгийн 1 ТАХ-г, Эрдэнэ сумын ИТХ-аас 82.3 сая төгрөгийн 4 ТАХ нийт 303.6 сая төгрөгийн өртөгтэй 30 ТАХ-г шууд баталсан байна. Жич: Тонхил сумын санал эрэмбэлэлтийн материал аудитад хамрагдаагүй. Энэ зөрчил жил бүр дахин давтан гарсаар байгаа нь ИТХ-ын гишүүдэд хариуцлага тооцох хариуцлагын эрх зүйн тогтолцоо байхгүйтэй шууд холбоотой байна. /хавсралт №6/

2.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь шаардлагыг хангаагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр баталж, санхүүжүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2016 онд ОНХС-аас хэрэгжүүлэхээр баталсан нийт 4,611.5 сая төгрөгийн өртөгтэй 345 ТАХ-г ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгавар хийгдсэн эсэхийг дараах байдлаар харууллаа. Үүнд:

- Хуульд заасны дагуу ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв, ажлын даалгавар батлагдсан 3,488.4 сая төгрөгийн өртөгтэй 201 ТАХ

⁵ Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа

⁶ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

⁷ Энэ журмын 12.2.1 а-д заасан хэлбэрээр санал асуулгыг явуулахдаа, жил бүрийн 2 дугаар улирлын эхний 30 өдөрт багтаан санал авна.

⁸ Хөтөлбөр, төсөл арга хэмжээг санхүүжүүлснээс бий болгох үр өгөөжийг хэн хүртэх

⁹ Хэдэн хүн ашиг хүртэх

¹⁰ Сум дүүргийн иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх

¹¹ Төслийн нийт өртөг зэргийг тусгана

- ТЭЗҮ, зураг төсөв шаардлагагүй /баяр наадам, урсгал зардал/ 835.8 сая төгрөгийн өртөгтэй 80 ТАХ
- ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгавар батлагдаагүй 178.3 сая төгрөгийн өртөгтэй 23 ТАХ
- ТЭЗҮ зураг төсөв шаардлага хангахгүй 109.4 сая төгрөгийн өртөгтэй 41 ТАХ тус тус байна.

Дээрх зөрчилтэй 23 болон 41 ТАХ нь Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7¹² дахь шаардлагыг хангаагүй байна. /хавсралт №7/

Тухайлбал: Хөхморьт сум нь худаг сэргээн засварлахаар 40 ТАХ-г хэрэгжүүлсэн боловч ЗДТГ-аас ТЭЗҮ, ажлын даалгаврыг нарийн гаргаж өгөөгүйгээс тухайн худгуудыг засварлах ажлууд харилцан адилгүй хийгдсэн байна. Ажлын даалгавар тодорхой бус, өмнө нь тухайн худаг ямар байсныг нотлох баримт байхгүйгээс шалгуур үзүүлэлт хангагдахгүй байна.

Иймээс засварласан худгуудыг харьцуулсан шинжилгээ хийж үзэхэд боломжийн хийгдсэн 5, дунд буюу нэмэлт ажил гүйцэтгэх шаардлагатай 17 худаг, муу буюу дахин гүйцэтгэх шаардлагатай 5 худаг, огт хийгдээгүй 9 худаг байна. Эндээс ТЭЗҮ, зураг төсвийг нарийн баталж өгөөгүйгээс ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцөл бүрдүүлж байна.

2.4 Сумууд төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд шинээр хэрэгжүүлсэн нийт 4,611.5 сая төгрөгийн 345 ТАХ-г худалдан авах ажиллагааг тооцож харуулбал дараах байдалтай байна.

График1: Худалдан авах ажиллагааны журам



Дээрх графикаас харахад нийт хэрэгжсэн ТАХ-ны 245 буюу 71% нь шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь хөтөлбөр буюу урсгал зардал их хэмжээгээр гарсантай холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зааварт хуульд заасан бусад чиг үүргийг тодорхой тусгаж зааж өгөөгүйгээс сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах үндэслэл болж байна.

¹² Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх

Сумдад сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахдаа сумууд нь төсөвт өртгийг хуваан шууд гэрээ байгуулсан, үнэлгээний хороо нь 3 гишүүнтэй буюу эрх зүйн чадамжгүй, 10.0 сая төгрөгөөс дээш өртөгтэй бараа ажил үйлчилгээн дээр шууд гэрээ байгуулсан, үнэлгээний хорооны дүгнэлтийн огноо, шууд гэрээ байгуулсан огнооноос хойно гарсан гэх мэт нийт 11 ТАХ-ны 290.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь ТБОНАХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.2¹³, 7.2¹⁴, 8.5¹⁵, 47.4¹⁶ дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй болохыг харуулж байна. Тухайлбал: Алтай, Бигэр, Дэлгэр, Халиун, Цогт, Цээл сумд/хавсралт №8/

2.5 Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн 63%-ийг хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад ТАХ-нд зарцуулжээ.

Сангийн сайдын 2014 оны 43-р тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.4 дахь хуулийн заалтаар сумдын 2016 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, гэрээ байгуулсан төсөл арга хэмжээг багцалж тооцоход:

Гэрээ байгуулж зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгийн:

- 9% буюу 226.3 сая төгрөгийг сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог, зайлуулалтыг хийх чиглэлд,
- 47% буюу 1,186.9 сая төгрөгийг хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд,
- 10% буюу 265.0 сая төгрөгийг нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийхэд,
- 4% буюу 95.4 сая төгрөгийг малжуулахад,
- 7% буюу 169.5 сая төгрөгийг сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулахад,
- 15% буюу 379.1 сая төгрөгийг сумын тохижилт, мод ургамал цэцэрлэгжүүлэлт явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах, арчлахад,
- 3% буюу 84.5 сая төгрөгийг нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахад
- 5% буюу 123.7 сая төгрөгийг хуульд нийцэхгүй хөтөлбөр, төсөл арга хэмжээнд буюу зориулалт бусаар зарцуулсан байна. /хавсралт №9, 10/


¹³ Хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.

¹⁴ Сум дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болно.

¹⁵ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

¹⁶ Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

График 2: Сумдын 2016 оны ОНХС-ийн хөрөнгийг зарцуулалт/сая.төг/




Мөн сумдын ОНХС-ийн зарцуулалтыг өмнөх оны зарцуулалттай харьцуулан үзвэл: Хуульд заасан бусад чиг үүргээр 2015 онд хэрэгжүүлсэн ТАХ 19% байсан бол 2016 онд 47% болж 2 дахин өссөн, хуульд заагаагүй төсөл арга хэмжээ 2015 онд 3%-ийг эзэлж байсан бол 2016 онд 5% болж өссөн, бусад чиг үүргүүдийн хувьд буурсан үзүүлэлттэй байна.

Сумдад веб сайт хийхээр иргэдээс санал авалгүйгээр ИТХ-аас шууд баталж санхүүжүүлсэн, Хөхморьт сум нь иргэддээ өвөлжөө хаваржааны хашаа засварлахаар 40 иргэнд тус бүр 1.0 сая төгрөг өгөхөөр гэрээ байгуулсан, Есөнбулаг сумын ОНХС-аас хүнсний ногооны зоорь барьсан зэрэг нийт 123.7 сая төгрөгийн 57 ТАХ нь зориулалт бусаар зарцуулсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.2 дахь заалтаар задалбал:

- ОНХС-ийн зааврын 7.2.4 дахь заалт буюу аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх чиглэлд 10%-ийг буюу 100.0 сая төгрөгийг
- 7.2.6 дахь заалт буюу усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, орон сууц, нийтийн аж ахуй, үерийн хамгаалалтыг зохион байгуулах чиглэлд 3% буюу 27.0 сая төгрөгийг
- 7.2.10 дахь заалт аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж, талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулахад 2% буюу 94.0 сая төгрөгийг
- 7.2.11 дахь заалт аймгийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 13 % буюу 129.5 сая төгрөгийг
- 7.2.12 дахь заалт хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд 2% буюу 21.1 сая төгрөгийг
- Хуульд нийцэхгүй хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 63% буюу 646.0 сая төгрөгийг зарцуулжээ. /хавсралт №10/

График 3: Аймгийн 2015-2016 оны ОНХС-ийн хөрөнгийн харьцуулсан судалгаа /сая.төг/



Аймгийн 2015 оны ОНХС-ийн хөрөнгийн 32% буюу 799.6 сая төгрөг нь хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох чиглэлд зарцуулагдаж байсан бол 2016 онд 63% буюу 646.0 сая төгрөгийг хуульд заагаагүй төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. Энэ нь жил ирэх тусам ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт үр ашиггүй урсгал зардалд зарцуулагдаж байгааг харуулж байна. Тухайлбал: Дараах урсгал зардалд ОНХС-ийн хөрөнгийг зарцуулсан байна.

- ОНХС-ийн заавар журамд нийцэхгүй 200.0 сая төгрөгийг зориулалт бусаар үйлдвэрүүдэд зээл олгосон байна.
- Геннисийн дээд амжилт 61 дэх цуврал номноос 30ш, боловсролын салбарын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэрээр зохиолч С.Пүрэвийн 802 ш 15.4 сая төгрөгийн ном авсан боловч хаана хэн хүлээн авч, хэрхэн зарцуулсныг нотлох баримтгүй.
- Боловсролын салбарын хөтөлбөрийн хүрээнд 140.6 сая төгрөгийг амжилт гаргасан сурагч, багш, сургууль, цэцэрлэг, эцэг эхийн зөвлөлийг шагнаж урамшуулсан, 15.2 сая төгрөгийг шалгалт зассан гишүүдэд ажлын хөлсөөр олгосон,
- Боловсролын салбарын хөтөлбөрийн хүрээнд багш нарын замын зардал, сургалтын төлбөрт 15.6 сая төгрөгийг зориулалт бусаар олгосон,
- Иргэн Г.Гансүхэд 1.0 сая төгрөгийн, “Эрүүл Ус” ОНӨААТҮГ-т 36.5 сая төгрөгийн, Бугат сумын ЭМТ, Соёлын төвд 14.6 сая төгрөгийн, Дарив сумын ЗДТГ-т 14.6 сая төгрөгийн нийт 66.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- Алим, усан үзэм хөтөлбөрийн хүрээнд 57.8 сая төгрөгийг суулгац авах, туршилтын тариалалт хийх хүмүүсийн цалин, томилолт, шатахуун гэх мэт урсгал зардалд зарцуулсан.
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 10.0 сая төгрөгөөр Элсний фестиваль зохион байгуулсан.
- Бусад хөтөлбөрийн хүрээнд байгаль хамгаалагч нарын биосан сургалтад 1.18 сая төгрөг, Бургастай боомтод баригдсан Гаалийн барилга хүлээн авах ажилд 12.2 төгрөг, терроризмтэй тэмцэхэд 11.0 сая төгрөг, иргэн Г.Гансүхэд дэмжлэг 1.0 сая төгрөг, Хөглөгөр Их алтай DVD худалдан

авахад 8.2 сая төгрөг, хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд 2.0 сая төгрөг, шатрын аварга шалгаруулах тэмцээний шагналд 2.5 сая төгрөг, алтайн түншлэл үзэсгэлэн зохион байгуулахад 4.1 сая төгрөг, ОУ-ын Монгол ITM үзэсгэлэнд оролцоход 14.0 сая төгрөг, номонд танилцуулга байршуулахад 1.5 сая төгрөгийг нийт 57.68 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бараа материал, үндсэн хөрөнгө авсан байгаа бөгөөд тэдгээрийг тулгаж үзэхэд дараах зөрчил илэрсэн.

- Бургастай боомт дахь барилгыг хүлээн авахад 9.3 сая төгрөгийн барилгын материал Голланд байшин ХХК нийлүүлсэн гэх боловч, уг барилгын материалыг хүлээн авсан, зарцуулсан баримт материал байхгүй, тоолох гэсэн боловч ЗДТГ-ын эд хариуцагчаар дамжаагүй, мэдэхгүй гэсэн тайлбар өгсөн.
- Англи хэлний кабинетиин тоног төхөөрөмж хяналтын камер 1ш, хяналтын камерын дэлгэц 1ш, спикер 1ш нийт 0.512 сая төгрөгийн хөрөнгийг хүлээлгэн өгөөгүй дутуу нийлүүлсэн байна.
- Хөглөгөр Их Алтай DVD-г 328 ширхэгийг тус бүр нь 0.025 сая төгрөгөөр нийт 8.2 сая төгрөгөөр авсан бөгөөд тухайн хөрөнгө нь зарцуулагдаагүй, тоо хэмжээгээрээ складад байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэрэгцээ шаардлагагүй зүйлд зарцуулж байгааг харуулж байна.
- Боловсролын салбарын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 15.4 сая төгрөгийн номыг сургуулиудад тараасан жагсаалт ирүүлсэн боловч, тухайн сургуулиудтай холбоо барихад ихэнх нь ирээгүй, ирсэн зарим нэг нь дутуу 10-12 ш ирсэн гэх тайлбарыг өгсөн. Иймд тухайн бараа материалыг хаана хэн хүлээн авч, хэрхэн зарцуулсныг нотлох баримтгүй, үлдэгдлээр байхгүй.
- Боловсролын салбарын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 9.1 сая төгрөгийн Бяцхан туслагч боть ном 9185 ширхэгийг худалдан авч тараасан гэх боловч, нотлох баримт байхгүй.
- Бургастай боомт дахь барилгыг хүлээн авахад 11.1 сая төгрөгийн мотор авсан бөгөөд, уг моторыг одоо хаана хэн эзэмшиж ашиглаж байгаа нь тодорхой бус байна.
- Аймгийн ЗД-ын нэрэмжит шалгалтыг зохион байгуулахад 2.8 сая төгрөгийн канон авсан бөгөөд одоогоор НББ-д орлогоор тусгаагүй БСГ дээр ашиглаж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хуульд заагаагүй чиг үүргийг хэрэгжүүлж, урсгал зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60.3 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 43

дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “ОНХС-ийн заавар”-ын 4.3¹⁷, 4.4¹⁸, 4.5¹⁹, 4.6²⁰ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

2.6 Хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг ЗДТГ-ын мэргэжилтнүүд тавьж ажилласан байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн буюу гэрээ байгуулан санхүүжилт олгосон 3,674.4 сая төгрөгийн 278 ТАХ-ээс 312.9 сая төгрөгийн 23 ТАХ-нд сумдын ЗДТГ-аас захиалагчийн хяналт тавьж ажиллаагүй, 791.3 сая төгрөгийн 82 ТАХ-нд захиалагчийн хяналт тавих шаардлагагүй /урсгал/ байна.

д/д	Сумын нэр	1.Захиалагчийн хяналт							
		Хэрэгжсэн төсөл арга хэмжээ		Хяналт тавьсан төсөл арга хэмжээ		Хяналт тавих боломжгүй		Хяналт тавьж ажиллаагүй төсөл арга хэмжээ	
		тоо хэмжээ	гэрээний дүн	тоо хэмжээ	гэрээний дүн	тоо хэмжээ	гэрээний дүн	тоо хэмжээ	гэрээний дүн
1	Сумын дүн	260.00	2,656.6	165.00	2,198.4	72.00	145.3	23.00	312.9
2	Аймаг хөгжлийн сан	18.00	1,017.7	8.00	371.7	10.00	646.0	0	
	Нийт дүн	278.00	3,674.4	173.00	2,570.1	82.00	791.4	23.00	312.9

Тухайлбал: Захиалагчийн хяналтыг дутуу хэрэгжүүлсэн Дарив, Баян-Уул, Шарга, Жаргалан, Цогт, Хөхморьт, Чандмань, Эрдэнэ сумууд байна. /Хавсралт №11/

Захиалагчийн хяналтыг тавихад мэргэжлийн чадвар дутмагаас гүйцэтгэгч байгууллагад шаардлага бүрэн тавьж чадаагүй, зайлшгүй шаардлагатай багаж тоног төхөөрөмжгүй, захиалагчийн хяналтын зардал байхгүйгээс ТАХ үр дүнгүй хэрэгжихэд хүргэх эрсдэлтэй юм.

ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг тухайн төлөвлөсөн саруудад хуваарийн дагуу олгоогүйгээс ажил удаашрах, гэрээний хугацаа хэтрэх үзэгдлүүд нилээд гарсан байна.

Мөн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ нь Ерөнхий гэрээний загвараар байгуулсан боловч, ерөнхий болон тусгай нөхцлийг тодорхой тусгаагүй, 2 тал харилцан баталгаажуулаагүйгээс гүйцэтгэгчид давуу байдлыг олгож, хөрөнгө оруулалтын ажил чанар муутай хийгдэх үндэслэл болсоор байна.

2.7 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгөнөөс 186.2 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд 3,159.0 сая төгрөгийн өртөгтэй 199 ТАХ, өмнөх оны дутуу хийгдсэн 1,410.2 сая төгрөгийн өртөгтэй 26 ТАХ-г хүлээн авчээ. Эдгээрээс

¹⁷ ОНХС-гаас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх

¹⁸ Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагын хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх

¹⁹ ОН-ийн төсвийн бус байгууллагад ОНХС-гаас хөрөнгө зарцуулахгүй байх

²⁰ ОНХС-гийн хөрөнгийн буцалтгүй тусламж, дэмжлэгт зарцуулахгүй байх

186.2 сая төгрөгийн 20 ТАХ-г НББ-д тусгаагүй байна. Энэ нь ОНХС-ийн зааврын 43-р тушаалын 8.6²¹ дахь заалтыг зөрчсөн байна. /хавсралт № 12/

Хүснэгт №4: Хүлээн авсан ТАХ-г НББ-д тусгасан байдлыг харвал:

д / д	сумын нэр	Хүлээн авах арга хэмжээ				НББ-ын бүртгэл тусгасан эсэх					
		2016 оны шинэ ажил		Өмнөх оны ажил		НББ-д тусгаагүй		НББ-д тусгасан		НББ-д тусгах нийт дүн	Хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан /Орлого авах боломжгүй/
		тоо хэмжээ	гэрээний дүн	тоо хэмжээ	гэрээний дүн	тоо хэмжээ	гэрээний дүн	тоо хэмжээ	гэрээний дүн		
1	Сумын дүн	181	2,247.3	23	608.2	19	172.3	165	2,539.6	2,712.0	143,5
2	Аймаг хөгжлийн сан	18	911.7	3	802.0	1	13.96	20	1,053.7	4,057.7	646.0
	Нийт дүн	199	3,159.0	26	1,410.2	20	186.2	185	3,593.5	6,769.7	789.5

Тухайлбал: ОНХС-ийн хөрөнгийг НББ-д дутуу тусгасан Алтай, Дарив, Жаргалан, Тонхил, Халиун, Цээл, Чандмань, Шарга сумууд, Аймгийн ЗДТГ байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хийгдсэн ажлуудын 14%-ийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад хийсэн засвар, тохижилт, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгө оруулалтанд зарцуулагдаж байсан бол 2016 онд 24% болж өссөн байна. /хавсралт №15/

Тодруулга: Аймгийн ОНХС-аас 2014-2016 онд хэрэгжсэн Есөнбулаг сумын Баянхайрхан багийн 11-р гудамжны араар баригдах орон сууцны хорооллын дулаан цэвэр усны шугамын ажил нь 2016 оны 08 сарын 02-ны өдөр дуусч, улсын комисс хүлээн авсан, акт үйлдэж протокол хөтөлсөн байна. Гэвч холбогдох газраас тодруулга авахад комиссын нэг гишүүн зураагүй, тухайн ажил зураг төсвийн дагуу хийгдээгүй учраас хүлээн аваагүй гэсэн тайлбарыг өгснөөр уг ажлыг НББ-д тусгах эсэх нь тодорхой бус байна.

БҮЛЭГ 3: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ, ТАЙЛАН МЭДЭЭГ СУМУУД ИРҮҮЛЭЭГҮЙ ТУЛ ХЭЛЭЛЦЭЭГҮЙ БАЙНА.

3.1.ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооноос зарим ТАХ-д хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн буюу гэрээ байгуулан санхүүжилт олгосон 3,674.4 сая төгрөгийн 278 ТАХ-ээс 659.1 сая төгрөгийн 109 ТАХ-нд аймаг, сумдын ИТХ-аас хяналт тавьж ажиллаагүй, 791.4 сая төгрөгийн 82 ТАХ-нд ИТХ-ийн дэргэдэх Хяналтын хорооноос хяналт тавих шаардлагагүй /урсгал/ байна.

²¹ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ

д/д	сумын нэр	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ		2.Хяналтын хорооны хяналт					
				Хяналт тавьсан төсөл арга хэмжээ		Хяналт тавих боломжгүй		Хяналт тавьж ажиллаагүй төсөл арга хэмжээ	
		тоо хэмжээ	гэрээний дүн	тоо хэмжээ	гэрээний дүн	тоо хэмжээ	гэрээний дүн	тоо хэмжээ	гэрээний дүн
	Сумын дүн	260.00	2,656.6	128.00	2,143.9	72.00	145.4	102.00	367.4
	Аймаг хөгжлийн сан	18.00	1,017.7	1.00	80.0	10.00	646.0	7.00	291.7
	Нийт дүн	278.00	3,674.4	129.00	2,223.9	82.00	791.4	109.00	659.1

- Сумдын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооноос хяналтыг дутуу хэрэгжүүлсэн, хяналт тавьж ажиллаагүй 367.4 сая төгрөгийн 102 ТАХ байна. Тухайлбал: Баян-Уул, Дарив, Жаргалан, Хөхморьт, Цогт, Чандмань, Эрдэнэ сумуудын ИТХ-ийн дэргэдэх хяналтын хороод
- Аймгийн ИТХ-аас 08 дугаар сарын 16-ны 48 дугаар тогтоолоор ОНХС-аас хэрэгжсэн ажил үйлчилгээ, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хэрэгжсэн ажлуудын үр дүнд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг байгуулан ажилласан байна. Уг ажлын хэсэг нь аймгийн төвд хэрэгжсэн томоохон бүтээн байгуулалтын ажлуудад хяналт хийж, холбогдох газар хэлтэс, агентлагуудад үүрэг даалгавар өгч ажилласан байна. Харин сумдад хэрэгжсэн ТАХ-нд хяналт хийгдээгүй байна.
- ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийсэн баримт материалаа ирүүлээгүй тул хяналт хийсэн эсэхийг нотлох боломжгүй байна.
- Иргэд олон нийт иргэний нийгмийн байгууллагууд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын байдалд хяналт хийгээгүй, албан ёсны хяналт хийгдсэн нотлох баримтгүй байна.

Өмнөх онуудад хийгдсэн ТАХ-ын талаар:

Аудит хийх явцад өмнөх онд хэрэгжсэн 895 ТАХ-ээс 124 ТАХ-ны ашиглалт, хамгаалалтын байдалтай газар дээр үзэж танилцахад дараах 22 ТАХ зөрчилтэй байлаа.

1. Алтай сумын Хөв байгуулах, зам засварын ажлууд үерт урсан эвдэрсэн.
2. Баян-Уул сумын хэвлэлийн цехийн тоног төхөөрөмж хэрэгцээ шаардлага хангахгүй ашиглахгүй болсон бөгөөд тооллогоор 3 үйлдэлт принтер, стикер хэвлэгч, зургийн аппарат, хар өнгөтэй принтер, компьютер зэрэг нийт 6.3 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан. Мөн гудамжны 40 гэрэлтүүлгээс 27 шатсан байна.
3. Бигэр сумын наадмын талбайн дээвэр зарим хэсэгтээ нурсан.
4. Дарив сумын уурын зуухны барилгын ажил чанаргүй хийгдсэн цууралт үүссэн тул хүлээн авах боломжгүй болсон байна. Сумын ЭМТ-д нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахгүй болсон. Хүнд өвчтөний ор, пульсоксиметрийг ашиглаж байна. Учир нь анхнаасаа хэрэгцээ шаардлагад нийцэхгүй тоног төхөөрөмж авсан байна.

5. Дэлгэр сумын алим хөтөлбөр хэрэгжүүлсэн Тариан овоо хоршоо нь уг төсөл арга хэмжээг гүйцэтгэн 2016 оны 11 сарын 15-нд хүлээлгэн өгсөн боловч аудитаар бодит гүйцэтгэлийг үзэхэд 200ш суулгац нь хугарсан ургаагүй.
6. Тонхил сумын цэнгэлдэх хүрээлэнгийн урд асрын дээвэр нурсан, тор унасан
7. Төгрөг сумын Далантүрүүний хөв задарсан, даланг дагтаршуулаагүй тул заагтай чанар байдал муутай, Соёлын төвийн дээврээс ус гоожсон.
8. Халиун сумын алаг амны хадлангийн талбай хаших ажил хийгдээгүй, ахуй үйлчилгээний барилгын 2 давхарын хананы зарим хэсэгт хагаралт өгсөн, үүдний кордиорт байрлах халаалтын системээс тосол гоожсон, 1 давхарын барилгын дотор талын зүүн хойд болон зүүн урд хэсгийн хананд мөөгөнцөр үүссэн, хананы будаг зарим хэсэгт хуурсан байна.
9. Цогт сумын Баянтоорой тосгоны цэцэрлэгийн хайсны чанар байдал сайн хийгдсэн боловч будаг нимгэн дан будсан тул цоохортсон, ахмадын өрөөний дотор заслын ажил хангалттай бус зураг төсвийн дагуу хийгдээгүй байна. Тухайлбал дотор ханыг лакдах, таазанд гепс хийхээр зураг төсөвт тусгасан боловч хийгдээгүй, таазын хэсэгт хууралт үүссэн, спортын талбайн цемент хагарсан, тоглох боломжгүй болсон.
10. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Шарга суманд хийсэн гүн өрмийн худгаас ундны ус ашиглах боломжгүй болсон.
11. Жаргалан сумын Батсуурь аваргын хөшөөний 13 гэрэлтүүлэг устаж алга болсон, Шатрын танхимын зарим хөрөнгө тооллогоор дутагдсан алга болсон.
12. Цээл сумын ахуй үйлчилгээний барилгын хананд цууралт өгсөн, дотор хананы замаск хуурсан байдалтай байна.

Дотоод хяналт шалгалт сул байгаагаас өмнө онд хэрэгжсэн 235.5 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгүүдийн хадгалалт хамгаалалт сул, зарим хөрөнгө чанаргүй, эвдэрч хэмхэрч, ашиглагдахгүй байгаа нь хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэсэн мөн үр ашиггүй зарцуулалт болсныг харуулж байна.

3.2 ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг ихэнх сумууд ирүүлээгүй, ирүүлсэн сумдын тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.

Алтай, Бугат, Тайшир сумын тайлант онд хэрэгжсэн ТАХ-ний хагас жилийн, Алтай сумын жилийн эцсийн тайлан аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст ирсэн байна. Бусад сумдын тухайд тайлангаа ирүүлээгүй, Хөгжлийн бодлогын хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийгээгүй, аймгийн Засаг даргад танилцуулаагүй байна. Энэ нь “ОНХС-ийн заавар”-ын 10.1²², 10.2²³ дахь заалтыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ.

²² Сум дүүргийн ОНХС-ийн хэрэгжилт, явцын хагас жилийн тайланг жил бүрийн 07 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 01-ны дотор аймаг, нийслэлийн аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах эрх бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна.

²³ Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум дүүрэг тус бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатын ИТХ-аар жил бүрийн 02 дугаар сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ.

3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод мэдээлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллийг аймаг, сумууд мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудаст байршуулж иргэдэд танилцуулсан байна.

Шилэн дансанд 2017 оны төсвийг мэдээлсэн байдлыг үзэхэд Дарив, Жаргалан, Тайшир, Төгрөг, Хөхморьт, Цээл, Есөнбулаг сумууд зөрүүтэй мэдээлсэн байна.
[/хавсралт №13/](#)

3.4.Орон нутгийн хөгжлийн сангийн заавар нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11 дэх заалттай уялдахгүй байна.

Төсвийн тухай хуулийн 60.11-т “Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй” гэж заасан нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 1.1-т “...нутгийн засаг захиргаа иргэд, олон нийтийн оролцоотой, хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах...”, 4.2-т “тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх, 4.4-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх” гэсэн заалтуудтай зөрчилдөх нөхцөл үүссэн байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13.1-т “Баяр наадмыг зохион байгуулах талаар аймаг, сумын Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 13.1.3-т “баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан зарцуулах”,-аар тусгасан бөгөөд Төсвийн тухай хуулийн 60.3.3-т “үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардалд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно”, гэж заасан нь үндэсний баяр наадмын зардалд ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулах хэмжээг тодорхой тусгаж өгөөгүйгээс өндөр өртөгтэйгөөр зарцуулах эрсдлийг үүсгэж байна.²⁴ Монгол улсын Засгийн газрын 2010 оны “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” (наадмын санхүүжилт) 271 дүгээр тогтоол Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.5²⁵-ыг үндэслэн гарсан нь зөвхөн бөх, уяач, харваач, хурдан морины уралдаанд оролцсон хүүхдэд олгох бай, шагналын хэмжээг тогтоосон бөгөөд баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд зарцуулагдах зардлын хэмжээг²⁶ тогтоогоогүй байна.

Төсвийн тухай хуулийн 4.1.28-д ““орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан” гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор...”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 1.2-т “ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийн дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах...” гэж тус сангийн үндсэн зорилгыг тусгаж өгсөн байтал үр ашиггүй урсгал зардалд зарцуулагдсаар байна.

²⁴ Алтай сум баяр наадмын зардалд-6.5 сая, Хөхморьт сум баяр наадмын зардалд-10.0 сая, аймгийн баяр наадамын зардалд-30.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

²⁵ 11.1.5.бөх, уяач, харваач, хурдан морины уралдаанд оролцсон хүүхдэд олгох бай, шагналын хэмжээг тогтоох.

²⁶ 11.1.4.улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг батлах, зарцуулалтад хяналт тавих;


Тухайлбал: Гамшгийн арга хэмжээнд зөвхөн шатахууны зардалд Бигэр сум 1.0 сая, Тонхил сум 0.3 сая, Халиун сум 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан, аймгийн хэмжээнд 769.7²⁷ сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

3.5 Өмнөх аудитаар өгөгдсөн актын биелэлт 53%, албан шаардлагын биелэлт 96%-тай, хариуцлага тооцох санал 71.4%-тай байна.

ОНХС-ийн 2013-2015 оны хөрөнгийн зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитаар өгсөн, зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, орон нутгийн удирдлагууд ОНХС-ийн орлогын төлөвлөлт, хуваарилалт, бүрдүүлэлт болон сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд тодорхой ажил зохион байгуулаагүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчил дутагдал арилахгүй, давтан гарсаар байна.

ОНХС-ийн зарцуулалтад өмнөх онуудад хийсэн аудитаар өгсөн, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг графикаар харуулбал:

Хүснэгт № 4: Өмнөх шийдвэрийн хэрэгжилт



- Төлбөрийн актын хэрэгжилт: Аймгийн ОНХС-ийн 9.4 сая төгрөг, Бугат сумын 36.7 сая төгрөг, Хөхморьт сумын 5.0 сая төгрөг, Цогт сумын 5.2 сая төгрөг, Дарив сумын 1.54 сая төгрөг, Чандмань сумын 2.5 сая төгрөг, Халиун сумын 0.77 сая төгрөг нийт 61.1 сая төгрөгийн төлбөрийн акт биелэгдээгүй биелэлт 53%-тай байна
- Албан шаардлагын хэрэгжилт: Аймгийн ОНХС-ийн хувьд 155.5 сая төгрөг, Дарив сумын 3.4 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжээгүй буюу дундаж биелэлт 96%-тай байна
- Зөвлөмжийн хэрэгжилт: Аймаг, сумдын ИТХ-д 1 заалттай сумдад 17 заалттай зөвлөмж хүргүүлснээс 18 албан тушаалтанд өгсөн зөвлөмж хэрэгжин биелэлт 100%-тай байна.

Аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Аудитаар нийт 5,198.7 сая төгрөгийг зөрчлийг илрүүлэн 26.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,142.5 сая төгрөгийн зөрчилд 87 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага, 1 заалт зөвлөмжийг холбогдох байгууллага болон

²⁷ Ажлын баримт-2.7 Нягтлан бодох бүртгэл

албан тушаалтанд хүргүүлэн, ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт 3 заалт саналыг хүргүүллээ.

1. Иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг ЗДТГ эрэмбэлж оруулан батлуулж, санхүүжүүлсэн байна.
2. Иргэдээс санал аваагүй, ЗДТГ-аас өргөн бариагүй төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар шууд хэлэлцэн санхүүжүүлсэн байна.
3. Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн.
4. ОНХС-аас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг өөр эх үүсвэртэй давхардуулсан.
5. Техникийн тодорхойлолтод заасан ажлыг дутуу хийж гүйцэтгэсэн байхад ажлыг хүлээн авсан байна.
6. Төсөл арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолт боловсруулаагүй, тооцоо судалгаа хийгээгүй байна.
7. ОНХС-аар хийгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй
8. ИТХ-ийн дэргэдэх Хяналтын хорооноос хэрэгжсэн төсөл хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.
9. ОНХС-аас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд захилагчийн хяналт тавьж ажиллаагүй байна.
10. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын бодит гүйцэтгэлийг үзэхэд чанар байдал муутай.
11. ОНХС-гийн зааварт нийцээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн.
12. Аймгийн ИТХ-аас сумдад олгох шилжүүлгийг батлахдаа төсвийн тухай хуулийг зөрчиж баталсан байна.

ДҮГНЭЛТ

ОНХС-гийн эх үүсвэрээс 769.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 25 дахин өссөн үзүүлэлттэй, мөн дотоодын хяналт хангалтгүй байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэр гаргаж байна. Үүнд:

Санал

ҮАГ-ын Нийцлийн аудитыг газарт

1. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 1.1, 1.2, 4.2, 4.4 дэх заалтууд нь Төсвийн тухай хуулийн 60.11 дэх заалттай уялдаагүй байгааг судалж, өөрчлөлт оруулах талаар санал оруулах

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс үндэсний баяр наадмын зардалд зарцуулах зардлын хэмжээг тодорхой болгох талаар холбогдох албан тушаалтанд уламжилж өгнө үү.
3. Иргэдээс санал аваагүй, ЗДТГ-аас эрэмбэлж оруулаагүй төсөл арга хэмжээг Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь баталж байгаа зөрчилд хариуцлага тооцох эрх зүйн орчин бий эсэхийг тодорхойлж өгнө үү.

Зөвлөмж

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Т.Ганзориг танаа

1. Төсвийн тухай хууль болон холбогдох эрх зүйн актыг мөрдөж ажиллах

Төлбөрийн акт

Аймгийн Засаг дарга С.Гансэлэм танаа:

1. Зориулалт бусаар зарцуулсан 5.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-гийн дансанд 2017 оны 09 сарын 15-ны дотор төвлөрүүлэх

Хөхморьт сумын Засаг дарга Н.Үйтүмэн танаа

1. Зориулалт бусаар зарцуулсан 21.15 сая төгрөгийг 2017 оны 09 сарын 15-ны өдрийн дотор ОНХС-д төвлөрүүлэх

Чандмань сумын Засаг дарга Н.Дагвадорж танаа

1. Зориулалт бусаар зарцуулсан 0.16 сая төгрөгийг 2017.09.15-ны өдрийн дотор ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх

Албан шаардлага

Аймгийн ОНХС

Аймгийн Засаг дарга С.Гансэлэм

1. Зээлээр олгосон 200.0 сая төгрөгийг 2017 оны 09 дүгээр сарын 15-ны дотор төвлөрүүлэх
2. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгүүдийг бүртгэлд тусган 2017 оны 06 сарын 01-ний дотор тайланг ирүүлэх
3. Иргэдийн санал авсан төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх
4. Барилгын засварын материалд 9.3 сая төгрөгийг зарцуулсан эсэхэд хяналт шалгалт хийн 2017 оны 06 сарын 01-ний дотор тайланг ирүүлэх
5. ОНХС-ийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж дотоод хяналтыг эрчимжүүлэх
6. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулан, дутуу нийлүүлсэн хөрөнгийг бүрэн хүлээн авч, тайланг 2017 оны 07 сарын 01-ний дотор ирүүлэх
7. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудын гүйцэтгэлийг давтан шалгаж тайланг ирүүлэх, цаашид ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх

8. Бүрэн эрхийн хүрээнд ажлын гүйцэтгэлд дахин хяналт тавьж хуулийн дагуу шийдвэрлэх

Сумдын ИТХ-ийн дарга нарт

1. ЗДТГ-аас эрэмбэлэн оруулсан иргэдийн санал авсан арга хэмжээг ОНХС-ийн заавар журамд нийцүүлэн баталж байх
2. Хяналтын хорооны ажлын үр нөлөөг дээшлүүлэн, үр дүнг хэлэлцэн, зөрчлийг тухай бүр арилгуулж ажиллах

Сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт

1. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэнд захилагчийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, зөрчлийг тухай бүр арилгуулан ажиллах /Баян-Уул , Дарив, Жаргалан, Хөхморьт, Чандмань, Эрдэнэ сум/
2. ХАА-г хууль журамд нийцүүлэн зохион байгуулах /Алтай, Бигэр, Бугат, Дэлгэр, Халиун, Цээл, Цогт сум/
3. Цаашид ОНХС-ийн зааврыг мөрдөн зөрчлийг давтан гаргахгүй байх /Дэлгэр, Төгрөг, Цогт, Чандмань сум/
4. ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх /Сумууд, аймаг/
5. НББ, данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийг холбогдох байгууллагын дансанд орлого авах /Алтай, Дарив, Жаргалан, Тонхил, Цээл, Чандмань сум/
6. Зураг төсөв, техникийн тодорхойлолт боловсруулаагүй төсөл арга хэмжээний гэрээг байгуулахгүй, эхлүүлэхгүй, санхүүжүүлэхгүй байх /Бигэр, Жаргалан, Тайшир, Төгрөг, Халиун, Чандмань/
7. Чанар байдал муутай хийгдсэн ажлыг гүйцэтгэгчээр дахин засварлуулж хэвийн үйл ажиллагааг хангах /Алтай, Баян-Уул, Бигэр, Дэлгэр, Хөхморьт, Цогт, Цээл, Эрдэнэ, Есөнбулаг/
8. Чанар байдал муутай, дутуу хийгдсэн төсөл арга хэмжээг 2017 оны 06 сарын 31-ий дотор бүрэн гүйцэтгэж ажлын тайланг фото зургийн хамт ирүүлэх /Алтай сум/

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Харилцагч байгууллагаас ирүүлсэн санал



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

82091 Харзат, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг,
Утас/Факс: (01-482) 2-40-42,
E-mail: Gobi_altai 2005@yahoo.com

2017.04.28 № 6/639

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны гүйцэтгэлд хийгдсэн нийцлийн аудитын шалгалтын дүнгийн төсөлтэй танилцан дараах саналыг хүргүүлж байна.Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг зөрчиж жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон 200,0 сая төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан.

2016 оны төсвийн тухай тогтоолыг үндэслэн аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч зээлийн гэрээ байгуулан энэхүү зээлийг олгосон байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө нь аймгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн батлагддаг учир эрх мэдлээ хэтрүүлсэн, хууль зөрчсөн үйлдэл болоогүй гэж үзэж байна.

Цаашид орон нутгийн хөгжлийн сангаас бусад эх үүсвэрээр жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх санг байгуулах боломжийг судалж хэрэгжүүлэх тул албан шаардлага болгож өгөх

2. Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн дагуу шагнал, ажлын хөлс, замын зардал, бичиг хэргийн зардалд зарцуулсан 181,7 сая төгрөгийн актыг нарийвчлан судалж олон хүнд хүрсэн, дансаар дамжин олгогдсон зардлуудыг актаас хасч тооцох

3. Буцалтгүй тусламжаар олгосон 3 байгууллага, сумтай холбоотой 66,7 сая төгрөгийн актыг албан шаардлага болгон тус тус өөрчилж өгнө үү.

Бусад санал дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ч.ЖАРГАЛСАЙХАН



02 000837

Саналд хариу хүргүүлэх тухай

1. ОНХС-гаас зээл олгосон нь Төсвийн тухай хуулийн 60.3.5 дах заалт /Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах/, СС-ын 2014 оны 43-р тушаалын хавсралтаар батлагдсан ОНХС-гийн зааврын 4.3 дахь заалтыг зөрчсөн байна. Танай саналыг хүлээн авч ОНХС-д оруулахаар хугацаатай албан шаардлагаар орууллаа.
2. Боловсролын салбарын хөтөлбөрөөр олгосон 181.0 сая төгрөгөөс 5.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, үлдсэн зарцуулалтыг хянаж, тайланг манайд ирүүлэхээр албан шаардлага хүргүүллээ.
3. Буцалтгүй тусламжид оруулсан 3 байгууллага, сумтай холбоотой 66.7 сая төгрөгийн төлбөрийн актыг албан шаардлагаар орууллаа.